



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/58/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: Tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016 Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn</p>
Алтай хот 2022 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.9.2 Худалдан авах ажиллагаа	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Төлбөрийн акт.....	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.БАТТАЙВАН ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.22 № 07
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020038

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,875,363.46	39,011,374.41
33	АВЛАГА	7,390,996.00	12,626,299.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	5,235,303.00
33500	Бусад авлага	7,390,996.00	7,390,996.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	7,390,996.00	7,390,996.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,484,367.46	26,385,075.41
35100	Түүхий эд материал	63,500.00	86,000.00
35130	Эм боох материал	63,500.00	86,000.00
35400	Хангамжийн материал	41,420,867.46	26,299,075.41
35410	Бичиг хэргийн материал	3,866,332.41	4,013,332.41
35420	Аж ахуйн материал	9,512,443.00	8,438,543.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,492,300.00	478,800.00
35440	Түлш, шатах тослох материал	15,338,322.05	13,216,000.00
35460	Хүнсний материал	4,211,470.00	152,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	721,098,594.23	842,303,969.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	721,098,594.23	842,303,969.04
39200	Биет хөрөнгө	363,070,677.48	478,409,969.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	323,326,088.02	352,955,206.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-28,831,193.29	-43,029,997.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	83,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,250,000.00	-8,750,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	51,671,241.00	77,027,041.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,500,775.60	-15,657,606.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,632,272.00	48,207,107.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,036,954.65	-15,401,782.47
39217	Ном	60,000.00	60,000.00
39300	Биет бус хөрөнгө	358,027,916.75	363,893,999.98
39301	Програм хангамж	16,384,000.00	15,909,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,796,083.25	-1,455,000.02
39303	Бусад биет бус хөрөнгө	349,440,000.00	349,440,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	769,973,957.69	881,315,343.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	769,973,957.69	881,315,343.45
51	Засгийн газрын хувь оролцоо	769,973,957.69	881,315,343.45
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	711,196,643.74	361,756,643.74
51101	Өмч /төрийн/ /ГӨҮГ/	0.00	349,440,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	58,777,313.95	170,118,699.71
51210	Өмнөх үеийн үр дүн	-21,887,122.55	58,777,313.95
51220	Тайлант үеийн үр дүн	80,664,436.50	111,341,385.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	769,973,957.69	881,315,343.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	874,940,635.00	905,536,545.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,519,435.00	178,074,345.00
120	Нийтлэг татварын бус орлого	145,519,435.00	178,074,345.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,133,000.00	11,385,000.00

**Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,133,000.00	11,385,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	127,802,935.00	166,285,545.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,583,500.00	403,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	729,421,200.00	727,462,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	716,090,400.00	716,392,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	716,090,400.00	716,392,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,330,800.00	11,070,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	330,800.00	70,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,000,000.00	11,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	792,260,052.92	794,195,159.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	792,260,052.92	794,195,159.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	765,885,660.92	777,144,495.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,953,317.00	566,923,717.00
210101	Үндсэн цалин	563,953,317.00	566,923,717.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,250,357.00	74,692,626.62
210201	Тэтгэврийн даатгал	48,864,232.11	52,243,827.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,748,733.17	5,813,029.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,548,586.53	4,583,223.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,098,982.29	1,095,686.01
210205	Эрүүл мэндийн даатгал	10,989,822.90	10,956,860.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,390,400.00	42,316,435.67
210301	Гэрэл, цахилгаан	3,375,981.00	3,044,973.67
210302	Түлш, халаалт	33,704,243.00	38,357,846.00
210303	Цэвэр, бохир ус	2,310,176.00	913,616.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,449,485.64	32,345,973.19
210401	Бичиг хэрэг	6,731,100.00	2,627,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,881,549.95	9,616,921.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,273,285.00	1,903,882.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	562,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,363,550.69	4,775,600.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	12,859,670.00
2105	Нормативт зардал	7,689,750.10	7,028,745.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	130,100.10	92,890.00
210502	Хоол, хүнс	5,999,650.00	5,495,855.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,560,000.00	1,440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2,074,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	2,074,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,092,284.00	3,628,828.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	541,000.00	46,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,491,000.00	1,525,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	266,248.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	190,000.00	900,400.00
210807	Газрын төлбөр	709,284.00	846,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,060,067.18	48,134,170.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,060,067.18	47,134,170.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,374,392.00	17,050,663.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,217,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	975,900.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,157,392.00	70,000.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,157,392.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	70,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,000,000.00	15,980,663.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.00	15,980,663.57
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	82,680,582.08	111,341,385.76
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	80,664,436.50	111,341,385.76

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Аудитлагдсан үлдэгдэл		
	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	711,196,643.74	58,777,313.95	769,973,957.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	711,196,643.74	58,777,313.95	769,973,957.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	711,196,643.74	58,777,313.95	769,973,957.69
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	711,196,643.74	58,777,313.95	769,973,957.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	711,196,643.74	58,777,313.95	769,973,957.69
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	111,341,385.76	111,341,385.76
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	711,196,643.74	170,118,699.71	881,315,343.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	747,554,200.00	739,347,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,133,000.00	11,885,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,133,000.00	11,885,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,133,000.00	11,885,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,133,000.00	11,885,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734,421,200.00	727,462,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	716,090,400.00	716,392,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	716,090,400.00	716,392,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,330,800.00	11,070,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	330,800.00	70,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,000,000.00	11,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	747,554,200.00	737,293,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,554,200.00	737,293,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	720,866,308.00	715,007,233.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,953,317.00	566,923,717.00
210101	Үндсэн цалин	502,321,755.00	430,156,638.00
210102	Нэмэгдэл	54,689,562.00	106,520,567.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,942,000.00	30,246,512.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,250,357.00	74,692,626.62
210201	Тэтгэврийн даатгал	64,353,773.00	52,542,157.90
210202	Тэтгэмжийн даатгал	6,896,584.00	5,665,220.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	4,528,503.30
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,086,977.75
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	10,869,767.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,791,200.00	40,224,635.67
210301	Гэрэл, цахилгаан	3,375,981.00	3,044,973.67
210302	Түлш, халаалт	29,105,043.00	36,256,046.00
210303	Цэвэр, бохир ус	2,310,176.00	923,616.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,758,555.00	14,603,784.14
210401	Бичиг хэрэг	3,940,300.00	2,804,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,111,100.00	4,831,702.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,273,285.00	1,903,882.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	562,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,233,870.00	4,501,300.00
2105	Нормативт зардал	5,057,210.00	7,294,945.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,600.00	146,690.00
210502	Хоол, хүнс	3,491,610.00	5,708,255.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,560,000.00	1,440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,100,625.00	1,874,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,100,625.00	1,874,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,624,244.00	3,628,828.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	541,000.00	46,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,491,000.00	1,525,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	266,248.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	721,960.00	900,400.00
210807	Газрын төлбөр	709,284.00	846,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,330,800.00	5,764,697.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	5,764,697.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,330,800.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,687,892.00	22,285,966.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,530,500.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,289,400.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,157,392.00	5,305,303.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,157,392.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5,305,303.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,000,000.00	15,980,663.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.00	15,980,663.57
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	2,054,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	2,054,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	2,054,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	2,054,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	2,054,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-2,054,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	783,792,200.0	712,296,536.43	71,495,663.57	91%
УРСГАЛ ЗАРДАЛ	783,792,200.0	712,296,536.4	71,495,663.6	91%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,894,700.0	711,296,536.43	57,598,163.6	93%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,970,100.0	566,923,717.00	46,383.0	100%
Үндсэн цалин	434,844,000.0	430,156,638.00	4,687,362.0	99%
Нэмэгдэл	114,465,500.0	106,520,567.00	7,944,933.0	93%
Унаа хоолны хөнгөлөлт	17,660,600.0	30,246,512.00	(12,585,912.0)	171%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,541,000.0	74,692,626.62	1,848,373.4	98%
Тэтгэврийн даатгал	53,862,200.0	52,542,157.90	1,320,042.1	98%
Тэтгэмжийн даатгал	5,669,700.0	5,665,220.25	4,479.8	100%
ҮОМШӨ-ний даатгал	4,535,800.0	4,528,503.30	7,296.7	100%
Ажилгүйдлийн даатгал	1,133,900.0	1,086,977.75	46,922.3	96%
Эрүүл мэндийн даатгал	11,339,400.0	10,869,767.42	469,632.6	96%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,304,200.0	40,224,635.67	79,564.3	100%
Гэрэл, цахилгаан	4,294,200.0	3,044,973.67	1,249,226.3	71%
Түлш, халаалт	33,886,500.0	36,256,046.00	(2,369,546.0)	107%
Цэвэр, бохир ус	2,123,500.0	923,616.00	1,199,884.0	43%
Хангамж, бараа материалын зардал	16,189,500.0	14,603,784.14	1,585,715.9	90%
Бичиг хэрэг	3,373,700.0	2,804,500.00	569,200.0	83%
Тээвэр, шатахуун	3,447,800.0	4,831,702.00	(1,383,902.0)	140%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,622,000.0	1,903,882.14	718,117.9	73%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,506,700.0	562,400.00	1,944,300.0	22%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,239,300.0	4,501,300.00	(262,000.0)	106%
Нормативт зардал	22,440,000.0	7,294,945.00	15,145,055.0	33%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	400,000.0	146,690.00	253,310.0	37%
Хоол, хүнс	20,480,000.0	5,708,255.00	14,771,745.0	28%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,560,000.0	1,440,000.00	120,000.0	92%
Эд хогшил, урсгал засварын зардал	6,508,700.0	3,928,000.00	2,580,700.0	60%
Багаж, техник, хэрэгсэл	6,508,700.0	3,928,000.00	2,580,700.0	60%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,941,200.0	3,628,828.00	36,312,372.0	9%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,250,000.0	46,000.00	36,204,000.0	0%
Даатгалын үйлчилгээ	1,525,500.0	1,525,500.00	-	100%
Тээврийн хэрэгслийн татвар	304,200.0	266,248.00	37,952.0	88%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.0	44,000.00	55,000.0	44%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	912,700.0	900,400.00	12,300.0	99%
Газрын төлбөр	849,800.0	846,680.00	3,120.0	100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,897,500.00	1,000,000.00	13,897,500.00	7%

Бусад урсгал шилжүүлэг	14,897,500.0	1,000,000.00	13,897,500.0	7%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,866,000.0	-	13,866,000.0	0%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,031,500.0	1,000,000.00	31,500.0	97%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	783,792,200.0	712,296,536.43	71,495,663.6	91%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	716,392,200.0	700,411,536.43	15,980,663.6	98%
Улсын төсвөөс санхүүжих	716,392,200.0	700,411,536.43	15,980,663.6	98%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	67,400,000.0	11,885,000.00	55,515,000.0	18%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,400,000.0	11,885,000.00	55,515,000.0	18%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	51.0	51.0	-	100.00
Удирдах ажилтан	1.0	1.00	-	100%
Гүйцэтгэх ажилтан	50.0	50.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	11,070,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	11,070,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,764,697.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,764,697.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,764,697.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,305,303.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,305,303.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,305,303.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	11,070,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,070,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	70,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл ядуурлыг бууруулах иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 792.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.7 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.2 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 12.6 сая төгрөг болж өссөн нь тайлант онд татаас санхүүжилтийн 5.2 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой. Нэгээс дээш жилийн насжилттай шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 7.4 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 26.4 сая төгрөг болж 15.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 39.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 0.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 42.2 сая төгрөгийн материалыг зарцуулж, 12.8 сая төгрөгийн бараа материалыг акталжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 926.6 сая төгрөг болж 108.0 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 183.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 88.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж дахин үнэлж бүртгэлд тусгасан ба 35.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 881.3 сая төгрөг болж 111.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 22 хувиар буюу 163.0 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 170.1 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 892.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 108.7 сая төгрөгөөр бууруулж, 783.8 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс их байгаа нь цалингийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 716.4 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 67.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 716.4 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 11.9 сая төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 712.3 сая төгрөгийг зарцуулж 16.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 712.3 сая төгрөг буюу 91 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1.6 сая төгрөгөөр, нормативд зардлыг 15.1 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 2.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 36.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 11.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан 5.8 сая төгрөгийн орлогыг тайлагнаж 5.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Нэмэлт санхүүжилтийн орлогыг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, и-баримтын худалдан авалтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 4 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Худалдан авах ажиллагаа

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.6 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснээс шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад хандсан, бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шилжиж ирсэн хөрөнгийн ашиглалт, бараа материалын дансны зарцуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 88.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.7 сая төгрөгийн алдааг залруулж, 21.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 55.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

ХХҮЕГ-аас ирсэн 3.7 сая төгрөгийн Samsung tab S6 lite-ийг бараа материалын дансанд бүртгэснийг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Мөн нэр бүхий 2 компаниас 0.2 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

Татварын тодорхойлолтоор 7.8 сая төгрөгийн илүү, дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байсныг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

4.3 Албан шаардлага

Удирдлагын шийдвэргүйгээр өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэлээр 9.0 сая төгрөгийн бараа материал акталсан. Үүнээс 8.4 сая төгрөгийн 6 ширхэг Samsung tab S6 lite нь 2020 оны 12 сард орлого авсан, ашиглалтын хугацаа дуусаагүй, үндсэн хөрөнгийн шинжтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй 0.4 сая төгрөгийн тавилга, 1.4 сая төгрөгийн ажлын хувцас бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5-д "автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 7.4 сая төгрөгийн авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй, барагдаагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.4 сая төгрөгийн дутуу, 0.1 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Багаж, техник хэрэгслийн данснаас 0.4 сая төгрөгийн урсгал, засварын зардал, 2.0 сая төгрөгийн тавилга, техник хэрэгсэл худалдан авч зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг зөрчсөн, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 55.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 55.5 сая төгрөгөөр тасалсан.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" заалтыг хэрэгжүүлж ажиллах

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд батлагдсан анхан шатны маягтыг ашиглахгүй байна.
- 2.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн анхан шатны маягтыг ашиглах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	11	88.4	3	11.7			6	21.2	2	55.5